

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2015 оны 8 сарын 20-ны өдрийн  
15/15 тоот тогтоолын Хавсралт 1.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. АПУ хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх, хурлын зар, мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурал хуралдуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилт оршино.
- 1.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрт өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах үйл ажиллагааг энэхүү журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 1.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

### Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах.

- 2.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл тогтоох бөгөөд ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг жил бүрийн 03 дугаар сарын 01-ны дотор гаргана.
- 2.2 Саналын эрх бүхий хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах нэмэлт санал болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа тухайн санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад бичгээр гаргаж болно.
- 2.3 Энэ журмын 2.2-д заасан санал нь Компанийн хуульд тогтоомжид заасан үндэслэл, мэдээлэл, шаардлагыг хангаж байгаа эсэх болон хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалт, нэр дэвшигчдийн бүртгэлд бүртгэх эсэхийг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэж, хууль тогтоомжид заасан журмын дагуу санал гаргагчид мэдэгдэнэ.
- 2.4 Хурлын хэлэлцэх асуудалд санал оруулахад шаардагдах хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа саналын тоог тухайн санал гаргах өдрөөр тогтооно.
- 2.5 Хувьцаа эзэмшигчийн дэвшүүлэх санал нь тухайн саналыг хурлын хэлэлцэх асуудалд шууд тусгахуйцаар найруулан бичигдсэн байна. Мөн гаргах шийдвэрийн төслийг агуулсан байж болно.
- 2.6 ХЭХ-ын хэлэлцэх асуудалд дэвшүүлэх саналыг баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргэж болно, үүнд:

**АПУ ХК-ийн  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛ**

**ЭХ ХУВЬ**

- 2.6.1 Баталгаат шуудангаар дараах хаягаар явуулах: *АПУ ХК, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын анхааралд* (тухайн саналыг хүлээн авах эрх бүхий хүний нэр, албан тушаалыг бичнэ);
- 2.6.2 Биечлэн хүргэх, саналыг хүлээн авсан хүний гарын үсэг бүхий нотолгоог авна. *(ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсвэл компанид хаягласан бичиг баримтыг хүлээн авах эрх бүхий хүн)*
- 2.7 ХЭХ-ын хэлэлцэх асуудалд санал оруулах болон компанийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэхтэй холбогдсон саналыг хүргүүлэхдээ хувьцаа эзэмшигч нь гарын үсгээ зурна. Хэрэв тухайн саналд хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан бол хуулийн заалтын дагуу хийгдсэн итгэмжлэлийг (эсвэл итгэмжлэлийн баталгаажуулсан хувь) хавсаргана.
- 2.8 ХЭХ-ын хэлэлцэх асуудал болон нэр дэвшүүлэх саналыг бичгээр үйлдэх ба дараах асуудлыг тусгана:
- 2.8.1 Санал дэвшүүлж байгаа хувьцаа эзэмшигчийн нэр;
- 2.8.2 Эзэмшиж байгаа хувьцааны тоо ба төрөл;
- 2.8.3 Дэвшүүлж байгаа саналын тухай болон тухайн саналыг дэвшүүлэх болсон шалтгаан.
- 2.9 Компанийн удирдлагад нэр дэвшүүлэх тохиолдолд дараах мэдээллийг оруулна:
- 2.9.1 Нэр дэвшигдэж байгаа хүний овог, нэр;
- 2.9.2 Нэр дэвшигдэж байгаа хүн нь компанийн хувьцаа эзэмшигч бол түүний эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл;
- 2.9.3 Нэр дэвшүүлэх болсон шалтгаан;
- 2.9.4 Чухам ямар албан тушаалд нэр дэвшүүлж байгаа;
- 2.9.5 Тухайн нэр дэвшигчтэй холбогдсон бусад мэдээллийн материал;
- 2.9.6 Хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол нэр дэвшүүлж байгаа этгээд нь хуульд заасан хараат бус гишүүний шаардлагыг хангаж байгаа талаар саналдаа тусгах.
- 2.10 ТУЗ тухайн саналыг хянаж, саналыг хүлээн авснаас хойш ажлын арван таван (15) өдөрт багтаан саналыг хүлээн авч байгаа эсвэл татгалзаж байгаа талаар шийдвэр гаргана. ТУЗ нь хувьцаа эзэмшигчийн хэлэлцэх асуудлын талаар гаргасан санал, шийдвэрийн төслийн томъёоллыг өөрчлөхгүй.
- 2.11 ТУЗ тухайн саналыг хэлэлцэх асуудалд оруулах, эсвэл нэр дэвшүүлж байгаа хүнийг компанийн удирдлагад нэр дэвшигчдийн жагсаалтад оруулах эсэх талаарх ТУЗ-ийн





- шийдвэрийг тухайн саналыг дэвшүүлсэн хувьцаа эзэмшигчид шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдөрт багтаан, татгалзсан бол шалтгааны хамт мэдэгдэнэ.
- 2.12 ТУЗ дараах нөхцөлөөс бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хэлэлцэх асуудалд оруулах санал болон нэр дэвшүүлж байгаа хүний нэр дэвшигчдийн жагсаалтад оруулна:
- 2.12.1 Журмын 2.1-д заасан хугацаанд хувьцаа эзэмшигч өөрийн саналыг хүргүүлээгүй бол,
- 2.12.2 Журмын 2.1-д заасан шаардлагатай тооны хувьцааг санал гаргагч нь эзэмшээгүй бол,
- 2.12.3 Журмын 2.7, 2.8 болон 2.9-д заасан шаардлагыг хангаагүй бол,
- 2.12.4 Хэлэлцэх асуудалд оруулахаар дэвшүүлж байгаа санал нь ХЭЗ-ын эрх мэдлийн хүрээнд хамаарахгүй, эсвэл Хуулийн шаардлагыг хангахгүй бол.
- 2.13 ХЭХ-ын хэлэлцэх асуудалд оруулах хувьцаа эзэмшигчийн санал дээр нэмж, эсвэл хувьцаа эзэмшигчдээс санал огт ирээгүй, эсвэл компанийн удирдах байгууллагад нэр дэвшүүлж байгаа хүний тоо нийт сонгогдох хүний тоонд хүрэхгүй байгаа бол ТУЗ нь өөрийн үзэмжээр хурлаар хэлэлцэх асуудал нэмж санал оруулах эсвэл нэмж нэр дэвшүүлэх эрхтэй болно.

**Гурав. Хувьцаа эзэмшигчдийн хурал, хурал хуралдуулах шийдвэр гаргах,  
зарлах, мэдээлэх.**

- 3.1. АПУ хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
- 3.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор, ээлжит бус хурлыг шаардлагатай үед тус тус зарлан хуралдуулна.
- 3.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр зарлан хуралдуулна.
- 3.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас бусад хурал ээлжит бус хурал байна.
- 3.5. Дараах тохиолдолд ээлжит бус хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр зарлан хуралдуулна:
- 3.5.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн 50-иас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
- 3.5.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
- 3.5.3. Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;



- 3.5.4. Компанийн өр хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
- 3.5.5. Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;
- 3.5.6. Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
- 3.5.7. Хууль тогтоомж, компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.
- 3.6. Төлөөлөн удирдах зөвлөл энэ журмын 3.5.2-д заасан санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах, эсэх талаар шийдвэр гаргана.
- 3.7. Төлөөлөн удирдах зөвлөл энэ журмын 3.5.2-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах шийдвэр гаргасан тохиолдолд санал шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.
- 3.8. Төлөөлөн удирдах зөвлөл энэ журмын 3.6-д заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаагүй тохиолдолд 3.5.2-д заасан санал, шаардлага гаргасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно.
- 3.9. Хурал хуралдуулах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл эсхүл хууль тогтоомж, компанийн дүрэм, энэ журамд заасан этгээд гаргана.
- 3.10. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай шийдвэр нь хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан журмын шаардлагыг хангасан байх бөгөөд уг шийдвэрт Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д заасан зүйлийг заавал тусгана.
- 3.11. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах өдрийг шийдвэр гаргасан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хурал хуралдах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө, хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 10 дахь өдөр байхаар тус тус тогтоох бөгөөд хурал хуралдуулах тухай шийдвэрийг уг шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид холбогдох баримт бичгийн хамт хүргүүлж, хурлын зарыг шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэнэ.
- 3.12. Хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдөр гэж Хөрөнгийн биржийн цахим хуудсаар нийтэд мэдээлсэн өдрийг хэлнэ.
- 3.13. Хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын тов болон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг өөрчлөхийг хориглоно.





- 3.14. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, холбогдох баримт бичгийг хурал хуралдах өдрөөс 40-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдэд үйлчилж байгаа үнэт цаасны брокер, диллерийн байгууллагуудад хүргүүлнэ.
- 3.15. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, холбогдох баримт бичгийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, танилцуулах, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах үйл ажиллагааг хурал зохион байгуулах комисс гүйцэтгэнэ. Эдгээр үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны брокер, диллерийн байгууллагаар гэрээгээр зуучлуулан гүйцэтгүүлж болно.

**Дөрөв. Хурал хуралдуулах.**

- 4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийг хэрэгжүүлэх, хурлын зар мэдээлэл явуулах, хурлын баримт бичгийг бэлтгэх, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах зэрэг хурлын бэлтгэлийг бүрэн хангаж товлосон өдөр, цагт хурлыг хуралдуулах ажлыг зохион явуулах үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон комисс гүйцэтгэнэ.
- 4.2. Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон дарга удирдана.
- 4.3. Үнэт цаасны бүртгэл, хадгаламжийн байгууллагаас бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргасан нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч хуралд оролцох эрхтэй бөгөөд хувьцаа эзэмшигч нь Иргэний хуульд заасан бичгээр олгосон итгэмжлэлээр өөр этгээдийг төлөөлүүлэн оролцуулж болно.
- 4.4. Компанийн нийт гаргасан саналын эрх бүхий энгийн хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурлын ирцийг хүчин төгөлдөр болсон гэж үзнэ.
- 4.5. Хурлын ирц энэхүү журмын 4.5-д заасан хэмжээнд хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл үйлдэж, хойшлогдсон хурлын товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гаргаж, хурлыг хойшлуулсан тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид холбогдох баримт бичгийн хамт ажлын 4 хоногт хүргүүлнэ.
- 4.6. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдах өдрөөс 10 болон түүнээс дээш хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг зарлан мэдээлнэ. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй бөгөөд саналын эрхийн 30-аас дээш хувийг эзэмшигчид оролцсоноор хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцно.



- 4.7. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэж болохгүй бөгөөд хэрэв хэлэлцсэн бол тухайн асуудлаар гаргасан шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.
- 4.8. Хурлыг хурал хуралдуулах шийдвэрт заасан этгээд даргалж, урьдчилан бэлтгэсэн дараалал, дэгийн дагуу удирдаж явуулна.
- 4.9. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол АПУ (ХК) компанийн гаргасан энгийн нэг ширхэг хувьцаа нэг саналын эрхтэй байна.

**Тав. Шийдвэр гаргах журам ба баримт бичгийн хөтлөлт**

- 5.1. Дараах асуудлаар шийдвэрийг ХЭХ-д оролцогсдын 3\4 буюу дийлэнх олонхийн саналаар гаргана.
  - 5.1.1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг батлах,
  - 5.1.2. Компанийг өөрчлөн байгуулах,
  - 5.1.3. Компанийг татан буулгах ба татан буулгах комиссыг томилох,
  - 5.1.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх,
  - 5.1.5. Нэмэлт хувьцаа гаргах, гаргах хувьцааны тоог тогтоох, компанийн өрийг хувьцаагаар солих,
  - 5.1.6. Компанийн хувьцааг хуваах болон нэгтгэх,
  - 5.1.7. Хуульд заасан бусад асуудал.
- 5.2. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарлахтай холбогдсон нэмэлт өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулах эсвэл компанийн шинэ дүрэм баримталж эхлэхтэй холбогдсон шийдвэрт дараах байдлаар санал өгсөн бол шийдвэр гарсанд тооцно.
  - 5.2.1. ХЭХ-д саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх (3\4-аас цөөнгүй хувь нь оролцож санал өгсөн байх ба үүнд эрхээ хязгаарлуулж байгаа давуу эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн саналыг оролцуулахгүй),
  - 5.2.2. Эрх нь хязгаарлагдах гэж байгаа давуу эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн энгийн олонхын саналаар шийдвэр гаргана.
- 5.3. Бусад бүх асуудлаар ХЭХ-д оролцогч саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн энгийн олонхийн саналаар шийдвэр гаргана.
- 5.4. Тооллогын комисс нь санал хураалтын хураангуй дүн болон дүнгийн тэмдэглэлийн төслийг ХЭХ дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор бэлэн болгоно. Санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын тэмдэглэлд тооллогын комиссын дарга болон гишүүд гарын үсэг зурна.

**АПУ ХК-ийн  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛ**  
ЭХ ХУВЬ



- 5.5. ХЭХ-ын тэмдэглэлийг ХЭХ-ын нарийн бичгийн дарга хурал дууссанаас хойш 15 өдрийн дотор үйлдэж, тэмдэглэлд тэмдэглэл хөтлөгч, хурлын дарга нар гарын үсэг зурна. Тооллогын комиссын бэлтгэсэн санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэлийг ХЭХ-ын тэмдэглэлд хавсаргана.
- 5.6. ХЭХ-ын тэмдэглэлийг
- 5.7. ХЭХ-ын тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:
- 5.7.1. Компанийн хууль ёсны нэр ба хаяг,
  - 5.7.2. ХЭХ-ын төрөл (ХЭЭХ эсвэл ХЭЭБХ),
  - 5.7.3. ХЭХ-ын хэлбэр,
  - 5.7.4. ХЭХ-ын огноо болон хугацаа,
  - 5.7.5. ХЭХ хуралдсан газар,
  - 5.7.6. ХЭХ-ын хэлэлцсэн асуудал,
  - 5.7.7. Саналын хуудсыг бөглөж, компанид ирүүлэх шуудангийн хаяг хэрэв тийнхүү ирүүлж болохоор заасан байвал,
  - 5.7.8. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хүмүүсийн саналын тоо нь хэлэлцэх асуудал бүрт хамаарна,
  - 5.7.9. ХЭХ-д биечлэн оролцож байгаа хүмүүсийн саналын тоо нь хэлэлцэх асуудал бүрт хамаартна,
  - 5.7.10. Ирц бүрдсэн нөхцөлд өгсөн санал бүр нь тухайн асуудлын хувьд (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”) хүчин төгөлдөр байна.
  - 5.7.11. ХЭХ-аас хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол,
  - 5.7.12. ХЭХ-ын дарга, нарийн бичгийн даргын нэрс,
  - 5.7.13. ХЭХ-ын тэмдэглэл (протокол) үйлдсэн огноо,
  - 5.7.14. ХЭХ-ын шийдвэр.
- 5.8. ХЭХ-ын тэмдэглэлд бичсэн ХЭХ-ын асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол нь саналын хуудсанд бичигдсэн тухайн шийдвэрийн томъёоллоос өөр байж үл болно.
- 5.9. ХЭХ-ын тэмдэглэлд гарын үсэг зурагдсаны дараа, саналын хуудсуудыг лацдаж, компанийн архивт хадгална.
- 5.10. Тооллогын комиссын ХЭХ-ын санал хураалтын дүнгийн тухай илтгэлд дараах мэдээллийг тусгана:
- 5.10.1. Компанийн оноосон бүтэн нэр, хаяг,
  - 5.10.2. ХЭХ-ын төрөл \ХЭЭХ эсвэл ХЭЭБХ\ болон хуралдуулсан хэлбэр,
  - 5.10.3. ХЭХ-ын хуралдсан өдөр, байршил, хэрэв ХЭХ-ыг эчнээ хэлбэрээр хуралдуулсан бол саналын хуудсыг эргүүлэн хүлээн авах сүүлийн хугацаа,

**АПУ ХК-ийн  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛ**  
ЭХ ХУВЬ

- 5.10.4. ХЭХ-ын хэлэлцсэн асуудал,
- 5.10.5. ХЭХ-аар шийдвэрлэсэн асуудлууд,
- 5.10.6. Хэлэлцсэн асуудлаар ирц бүрдсэн эсэх тухай мэдээлэл,
- 5.10.7. Ирц бүрдсэн нөхцөлд хэлэлцсэн асуудал бүрээр өгсөн саналын тоо (“зөвшөөрсөн”, ”татгалзсан”, ”түдгэлзсэн”),
- 5.10.8. ХЭХ-аар хэлэлцсэн асуудал бүрээр өгсөн саналын хүчингүй болсон саналын хуудасны тоо,
- 5.10.9. Хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол,
- 5.10.10. Тооллогын комиссын үүргийг гүйцэтгэсэн хөндлөнгийн байгууллагын нэр, хаяг, тухайн байгууллагаас ХЭХ-ын Тооллогын комиссын ажлыг эрхлэн гүйцэтгэх эрх олгосон хүмүүсийн нэрс,
- 5.10.11. ХЭХ-ын дарга, нарийн бичгийн даргын нэр,
- 5.10.12. Тооллогын комиссын дарга болон гишүүдийн гарын үсэг,
- 5.10.13. Санал хураалтын дүнгийн тайланг бичсэн огноо.
- 5.11. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд нэгдмэл сонирхолтой талуудын хэлцэлтэй холбогдсон асуудал орсон бол ХЭХ-ын тэмдэглэл, тооллогын комиссын тэмдэглэл, санал хураалтын дүнгийн тухай тайланд тухайн асуудлаар дараах мэдээллийг оруулна.
- 5.11.1. Хувьцаа эзэмшигчдийн нэрсний жагсаалтад орсон, тухайн хэлцлийн хувьд нэгдмэл сонирхолгүй хүмүүсийн саналын тоо,
- 5.11.2. ХЭХ-д биечлэн оролцсон, тухайн хэлцлийн хувьд нэгдмэл сонирхолгүй хүмүүсийн саналын тоо,
- 5.11.3. Ангилал бүрээр өгсөн саналын тоо (“зөвшөөрсөн”, ”татгалзсан”, ”түдгэлзсэн”)
- 5.12. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд давуу эрхийн аль нэг төрлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарлах нэмэлт өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулах (шинэчлэн найруулсан дүрмийг батлах) эсвэл компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт нь хуулийн дагуу давуу эрхийн аль нэг төрлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарлах асуудал орсон бол ХЭХ-ын тэмдэглэл, тооллогын комиссын тэмдэглэлд тухайн асуудлаар дараах мэдээллийг оруулна.
- 5.12.1. Эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоог оролцуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хүмүүсийн саналын тоо,
- 5.12.2. Эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоо,
- 5.12.3. ХЭХ-д биечлэн оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын тоо, үүнд эрх нь

АПУ ХК-ийн  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛ

ЭХ ХУВЬ



хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоо орохгүй ба тэдгээр давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоог жичид нь гаргах,

5.12.4. Хэлэлцсэн асуудлаар өгсөн саналын ангилал бүрийн тоо (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”), үүнд эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын ангилал бүрийн (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”) тоог жич гаргах,

#### **Зургаа. Бусад.**

- 6.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахгүйгээр Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд зааснаар хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.
- 6.2. Эчнээ санал хураалт явуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 6.3. Энэ журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, төрийн зохицуулах байгууллага, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан журамд зааснаар шийдвэрлэнэ.

**АПУ ХК-ийн  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛ**

**ЭХ ХУВЬ**